

Төсөл

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

Журам батлах тухай

Амьтны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 36 дугаар зүйлийн 36.2, 36.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Амьтан болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах журам”-ыг 1 дүгээр, “Амьтныг сэргээн нутагшуулах үйл ажиллагааны аргачлал”-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Хавсралтаар батлагдсан журмын хэрэгжилтийг хангаж, холбогдох захиргааны байгууллагад мэдэгдэж зохих арга хэмжээг авч ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар /Г.Нямдаваа/-т үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн А-359 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
... оны ... дугаар сарын ... өдрийн ...
дугаар тушаалын дүгээр хавсралт

Амьтан болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах журам

Нэг. Ерөнхий зүйл.

1.1. Монгол Улсын нэн ховор амьтныг амьдаар болон Зэрлэг амьтан, ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн хавсралтад бүртгэгдсэн амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлээс бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Амьтны гаралтай түүхий эд зүйл гэдэгт Амьтны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.20 дахь заалтад заасныг ойлгоно.

1.3. Энэхүү журмын 1.3.-т заасны дагуу эрх шилжүүлэх гэрээ хийгдсэн тохиолдолд журмын 2.2, 2.4, 3.4, 3.5-д заасан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эрхийг эрх шилжүүлэн авсан байгууллага хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр. Амьтан болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах зөвшөөрөл олгох

2.1. Амьтан болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах иргэн, аж ахуйн нэгж, мэргэжлийн болон судалгааны байгууллагын хүсэлтийг хүлээн авсан албан тушаалтан ажлын 10 хоногт багтаан нягтлан үзэж, зөвшөөрлийг олгох эсэх талаар дүгнэлт гаргаж, шийдвэрлэнэ.

2.2. Зөвшөөрлийг олгох шийдвэр гарсны дараа хүсэлт гаргагч нь улсын тэмдэгтийн хураамжийг холбогдох дансанд тушаасан баримт, зөвшөөрлийн гэрчилгээний үнэ төлсөн баримтын хамт байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэг цэгийн үйлчилгээний төвд ирүүлнэ.

2.3. Зөвшөөрлийг тусгай хэвлэмэл хуудсаар олгоно.

2.4. Зөвшөөрлийг нэг удаа олгох ба зөвшөөрлийн хүчинтэй хугацаа олгосон өдрөөс хойш 60 хүртэл хоног байна.

2.5. Гурав буюу түүнээс дээш амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах бол тэдгээрийн жагсаалтыг хавсралт байдлаар зөвшөөрөлд хавсаргана.

2.5. Хүндэтгэх шалтгааны улмаас амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах

зөвшөөрлийг хүчинтэй хугацаанд ашиглаж чадаагүй тохиолдолд иргэн, аж ахуй нэгж байгууллагын албан хүсэлт, гаалийн удирдах төв байгууллагын лавлагааны хамт зөвшөөрлийн хугацаа дуусахаас 7 хоногийн өмнө байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

2.6. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлт, гаалийн удирдах төв байгууллагын лавлагаа, хүндэтгэх шалтгаан зэргийг нягтлан үзсэний үндсэн дээр зөвшөөрөл олгосон албан тушаалтан зөвшөөрлийн хугацааг 30 хүртэл хоногоор хоёр удаа сунгаж болно.

2.7. Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулаагүй тохиолдолд өмнөх зөвшөөрөл дээр гаалийн байгууллагын тэмдэглэгээг зайлшгүй хийлгэсэн тохиолдолд, уг зөвшөөрлийг ашиглан зөвшөөрөлд заасан тоо хэмжээг гүйцээн амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргаж, гадаад улсаас оруулж болно.

Гурав. Амьтан болон амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах

3.1. Зөвхөн мэргэжлийн болон судалгаа шинжилгээний байгууллага ховор болон элбэг амьтныг амьдаар нь гадаад улсаас оруулах, гадаад улсад гаргах үйл ажиллагааг зохион байгуулна.

3.2. Хувь хүн, аж ахуйн нэгж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас зохих зөвшөөрлөө авч мэргэжлийн болон судалгаа шинжилгээний байгууллагаар ховор болон элбэг амьтныг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах ажлаа хийж гүйцэтгүүлж болно.

3.3. Мэргэжлийн болон судалгаа шинжилгээний байгууллага нь амьтныг сэргээн нутагшуулах, хувийн цуглуулгын сан хөмрөг бүрдүүлэх, баяжуулах, соёл урлаг, амьтны хүрээлэн зэрэг ашигт шинж чанарыг ашиглах, судалгаа шинжилгээний зорилгоор амьтныг амьдаар нь гадаад улсаас оруулах, гадаад улсад гаргах хүсэлтээ байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор гаргаж шийдвэрлүүлнэ.

3.4. Хүсэлтэд гадаад улсаас оруулах, гадаад улсад гаргах амьтны зүйлийн монгол, латин болон англи нэр, зориулалт, тоо толгой, импортлогч болон экспортлогч улс болон иргэн, байгууллагын нэр, хаяг, холбоо барих утасны дугаар, хилийн боомтын нэр, хилээр нэвтрүүлэх хугацаа зэргийг дурдахаас гадна дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

3.4.1. Мэргэжлийн байгууллагын гэрчилгээ, судалгааны байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.4.2. Амьтан барих зөвшөөрөл;

3.4.3. байгаль орчны улсын байцаагчийн дүгнэлт эсвэл акт, байгаль хамгаалагчийн тодорхойлолт;

3.4.4. Эзэмшлийн амьтан бол гарал үүслийн тодорхойлолт, зүүлт;

3.4.5. Тээвэрлэх, амьтныг түр байршуулах сав, технологийг тусгасан аргачлал;

3.5. Амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад албан ёсоор хүсэлтээ гаргана.

3.6. Хүсэлтэд гадаад улсаас оруулах, гадаад улсад гаргах амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийн зориулалт, тоо хэмжээ, амьтны зүйлийн монгол, латин болон англи нэр, импортлогч болон экспортлогч улс, иргэн, байгууллагын нэр, хаяг, холбоо барих утасны дугаар, хилийн боомтын нэр, гаргах оруулах хугацаа зэргийг дурдахаас гадна дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

3.6.1. Иргэний үнэмлэх, аж ахуй нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

3.6.2. Соёл урлаг, судалгаа шинжилгээ, тусгай зориулалтаар амьтан агнах, барих зөвшөөрлийн хуулбар;

3.6.3. Амьтны гаралтай түүхий эд, зүйлийн гарал үүслийн тодорхойлолт, зүүлт;

3.6.4. Амьтны гаралтай түүхий эд, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах талаар хүлээн авагч болон нийлүүлэгч талтай байгуулсан гэрээний хувь;

3.6.5. Амьтны түүхий эдийг худалдан авсан бол төлбөрийн баримт, худалдагч талын тодорхойлолт;

3.7. Зөрчлийн улмаас хураагдаж улсын орлого болгосон амьтны гаралтай түүхий эдийг гадаадад гаргах, гадаадаас оруулах хүсэлт гаргах тохиолдолд иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь энэ журмын 3.6.1, 3.6.3, 3.6.4-д зааснаас гадна дараах баримт бичгийг нэмж бүрдүүлнэ. Үүнд:

3.7.1. Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн ногдуулсан торгууль шийтгэвэрийн хуудас, түүнийг барагдуулсан тухай баримт бичиг;

3.7.2. Гэмт хэрэг, зөрчлийн улмаас хураагдсан эд зүйлийг шийдвэрлэх орон тооны бус зөвлөлийн шийдвэр;

3.7.3. Улсын орлого болгосон амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг иргэн, аж ахуйн нэгж байгууллагад худалдан борлуулах тухай Засаг даргын албан тоот, эсвэл захирамж;

3.7.4. Улсын орлого болгосон амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг худалдан авсан төлбөр төлсөн баримт;

3.8. Энэ журмын 2.6.-д заасан хүсэлтэд амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн тоо хэмжээ, амьтны монгол, латин, англи нэр, хил нэвтрүүлэх боомтын нэр, гадаадад гаргаж байгаа болон гадаадаас оруулж байгаа улс, байгууллагын нэр, хаяг зэргийг заасан байна.

Дөрөв. Бусад зүйл.

4.1. Амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйл, судалгааны ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн, хууль бусаар гаргахыг завдсан, хууль бусаар гаргасан, оруулсан зэрэг үйлдэл нь мэргэжлийн хяналт, хил, гааль, цагдаагийн байгууллагаар албан ёсоор нотлогдсон тохиолдолд тухайн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад 5 жилийн хугацаанд амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйлийг гадаад улсад гаргах, гадаад улсаас оруулах зөвшөөрөл олгохгүй ба өмнө олгосон зөвшөөрлийг хүчингүйд тооцно.

---o0o---

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
... оны ... дугаар сарын ... өдрийн ...
дугаар тушаалын дүгээр хавсралт

Амьтныг сэргээн нутагшуулах үйл ажиллагааны аргачлал

Нэг. Ерөнхий ойлголт.

1.1. Амьтныг сэргээн нутагшуулах гэдгийг Амьтны тухай хуулийн 4.1.6-д зааснаар ойлгоно.

1.2. Байгаль дээр устсан болон устах аюулд орсон амьтдыг өсгөн үржүүлэх зорилгоор сэргээн нутагшуулах төслийг тухайн амьтны түүхэн тархац нутгийн хүрээнд газар нутаг сонгон хэрэгжүүлнэ.

1.3. Иргэн, хуулийн этгээд байгаль дээр устсан болон устах аюулд өртсөн амьтныг өсгөн үржүүлэх зорилгоор амьтныг сэргээн нутагшуулах төслийг хэрэгжүүлэхэд энэ аргачлалыг баримтлана.

1.4. Энэхүү аргачлалд амьтныг сэргээн нутагшуулах үйл ажиллагааны үе шат, нутагшуулахад тавигдах шалгуур, шаардлагыг тусгалаа.

Хоёр. Бэлтгэл үе шат буюу орчны нөхцөл байдлыг үнэлэх, тодорхойлох урьдчилсан судалгаа хийх.

2.1. Сэргээн нутагшуулахаар сонгосон зүйл амьтны (цаашид амьтны гэх) амьдрах орчны үнэлгээ хийж, амьдрах орчны сонголтыг урьдчилан тодорхойлно. Үүнд:

2.1.1. Уур амьсгал, физик, хими, газарзүйн болон бусад хүчин зүйлийг тодорхойлох;

2.1.2. Амьтны тархацыг хязгаарлагч зүйл хоорондын хамаарлыг тодорхойлох (*амьдрах орчин идэш тэжээлийн өрсөлдөөн, өвчин ба шимэгч амьтан гэх мэт*);

2.1.3. Амьтны амьдрах орчны тохиромжтой байдлыг тодорхойлох (*тохиромжтой амьдрах орчин, идэш тэжээлийн хангамж сайн, хоргодох газар ихтэй, өвчний голомтоос ангид гэх мэт*);

2.1.4. Амьтны боломжит амьдрах орчныг үнэлэх (*амьдрах орчны даац, орон зайн хэмжээ, амьдрах орчны өөрчлөлт, хязгаарлагдмал амьдрах орчин гэх мэт*).

2.2. Популяцийн үнэлгээ хийх

2.2.1. Тохиромжтой газар нутагт тухайн зүйл амьтны амьдрах чадвартай хамгийн бага популяцийн хэмжээг тодорхойлох;

2.2.2. Амьтны амьдрах чадвартай хамгийн бага популяцийн тоо толгойн өсөлтийн дотоод чадавхийг тодорхойлох (*популяцийн нас, хүйсийн бүтэц, үхэл хорогдол, төрөлтийн дундаж эрчим, үр төлөрхөг байдал, мэнд үлдэлт гэх мэт*);

2.2.3. Түүхэн хугацаанд буюу сүүлийн 50-100 жилд тухайн амьтны популяцийн тоо толгойн хэлбэлзлийн чиг хандлага ямар байсныг тодорхойлох.

2.3. Тухайн зүйл амьтан устсан эсвэл тоо толгой буурсан шалтгааныг тодорхойлох.

2.3.1. Хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийн төлөв байдлыг тодорхойлж сөрөг нөлөөллийг бууруулсан, эсвэл багасгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлсэн, үр дүнд хүрсэн эсэхийг дүгнэх;

2.3.2. Тухайн зүйл амьтанд хандах нутгийн иргэдийн хандалагыг тодорхойлон, сэргээн нутагшуулах ажил амжилтад хүрэх бололцоотой эсэхийг дүгнэх сэтгэлгээний түвшинг тодорхойлон дүгнэлт гаргах.

2.4. Амьтныг сэргээн нутагшуулахад хүний үйл ажиллагаа хэрхэн нөлөөлөх аюул занал байгаа эсэх, дарамтын түвшинг үнэлэх.

2.4.1. Амьтан сэргээн нутагшуулахаар сонгосон газар нутгийн газар ашиглалтын урт хугацааны төлөвлөлт, бүс нутгийн болон орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төсөлтэй амьтан сэргээн нутагшуулах ажил хэрхэн уялдаж байгааг тооцоолох;

2.4.2. Одоо болон ирээдүйд эдийн засаг, дэд бүтцийн төслөөс сэргээн нутагшуулах зүйл амьтан, түүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлөх аюул дарамтын цар хүрээг тодорхойлон бууруулах боломжийг тодорхойлох;

2.5. Сэргээн нутагшуулах амьтныг барих, популяцийг сонгох, сэргээн нутагшуулах амьтныг барих, тээвэрлэх тухайн газрын популяцийн эрүүл байдал, популяцийн тоо толгойн өсөлтийн дотоод чадавхийг үнэлэх.

2.5.1. Амьтны амьдрах орчны дасан зохицох байдал болон учирч болох эрсдлийг үнэлэх;

2.5.2. Амьтныг сэргээн нутагшуулах газар, эх популяцийн амьдрах орчны нийцэл, ялгааг тодорхойлох;

2.5.3. Амьтны амьдрах орчны дасан зохицох байдал болон барих, тээвэрлэх, сэргээн нутагшуулах үед учирч болох эрсдлийг үнэлэх, бууруулах арга хэмжээ авах, технологийг нягтлан боловсронгуй болгох.

2.6. Амьтныг сэргээн нутагшуулах үндэслэл, төлөвлөгөө, арга зүй, технологийг нэгтгэсэн судалгааны тайлан, үр дүнг шинжлэх ухааны байгууллагаар хэлэлцүүлэн дүгнэлт гаргуулах.

2.7. Энэхүү аргачлалын 1.6-д заасан тайлан, шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтийг үндэслэн байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага амьтныг сэргээн нутагшуулах төслийг хэрэгжүүлэх эсэхийг шийдвэрлэнэ.

Гурав. Амьтныг сэргээн нутагшуулах төслийг боловсруулах үе шат

3.1. Бэлтгэл үе шатанд тодорхойлсон нөхцөл байдлын урьдчилсан дүн шинжилгээ, шинжлэх ухааны байгууллагын дүгнэлтэнд тулгуурлан амьтныг сэргээн нутагшуулах төслийн саналыг боловсруулах.

3.1.1. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн амьтныг сэргээн нутагшуулах арга зүйгээс тохирохыг сонгох эсвэл өөрийн орны нөхцөлд нийцүүлэн арга зүйг шинэчлэн боловсруулах;

3.1.2. Амьтныг түр байршуулах байр сав, тээвэрлэхэд тавигдах шаардлагыг боловсруулах;

3.1.3. Үржүүлгийн дэд хөтөлбөрийг боловсруулах;

3.1.4. Хяналт, судалгаа мониторинг, популяцийн мэдээллийн сангийн дэд хөтөлбөр боловсруулах;

3.1.5. Сэргээн нутагшуулах газрын байгаль хамгааллын менежментийн төлөвлөгөө, бизнесийн болон хүний нөөцийн төлөвлөгөө боловсруулах;

3.1.6. Эрсдэлийн төлөвлөгөө боловсруулах;

3.1.7. Бодгалиудыг байгальд суллан тавих, мониторинг хийх хөтөлбөр боловсруулна.

Дөрөв. Амьтан сэргээн нутагшуулах үе шат

4.1. Мэргэжлийн байгууллага нь Олон Улсын Байгаль Хамгаалах Холбоо /Species survival commission/-оос боловсруулсан сэргээн нутагшуулах аргачлалыг баримтлана.

4.2. Байгальд амьдрах чадвартай хамгийн бага популяцийг “зөөлөн суллах” арга зам буюу шинэ орчинд тодорхой хугацаанд дасгаж байгаад суллан тавих, эсвэл “хатуу суллах” аргаар буюу шинэ орчин газарт шууд суллан тавина.

4.3 Байгальд сэргээн нутагшуулахаар тавьсан популяцийн тоо толгойн өсөлт, популяцийн дотоод өрсөлдөөн, амьдрах орчны сонголт, махчлал зэрэг экологи, биологийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийж мэдээллийн санг тасралтгүй баяжуулна.

4.4. Энэхүү аргачлалын 3.3-т заасан мониторингийн үр дүнд тодорхойлсон шаардлагатай хамгааллын арга хэмжээг тухай бүрт авч хэрэгжүүлнэ.

4.5. Сэргээн нутагшуулах төслийн үйл ажиллагаанд 3 жил тутамд судалгаа шинжилгээний, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг гаргуулна.

4.6. Амьтан сэргээн нутагшуулах төслийн үр дүнг ашиглан аялал жуулчлал, олзворын болон спорт агнуур, загасчлал зэрэг бизнесийн үйл ажиллагаа явагдах тохиолдолд 2 жил тутамд байгаль орчны аудит хийлгэнэ.

4.7. Амьтан сэргээн нутагшуулах төслийн явцын жил бүрийн тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.